# ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН

## 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН



## СУРАЛЦАГЧ ЗАЙН, ЦАХИМ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХЭД ШААРДЛАГАТАЙ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ, СУРГАЛТЫН ЦАХИМ СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭХ, ГАМШГИЙН УЛМААС ТАНХИМЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООСОН ТОХИОЛДОЛД СУРГАЛТЫН ТАСРАЛТГҮЙ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ:

Сургуулийн удирдлагын систем “Амжилт-3.0”-ийг амжилттай нэвтрүүлэн ашиглаж байна.

“Утасгүй интернетийн ЕБС-4 багц”-ыг сургуульд байршуулсан. Давхар тус бүрт 1 төхөөрөмжийг суурилуулан ашиглаж байна. Ухаалаг самбар, төхөөрөмж бүхий хосолсон сургалтын 2 танхимыг шинээр бий болгож 4 танхимтай болсон. Төгсөгчдийн хандив 21355500 төгрөг, “Mind Tech” компанийн хөрөнгө оруулалтаар физикийн кабинетад 9500000 төгрөгийн ухаалаг дэлгэцтэй болж, дижитал багаж, тоног төхөөрөмж ашиглах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.







## ХҮҮХЭД БҮРИЙН ЯЛГААТАЙ ХЭРЭГЦЭЭ, ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ, ТЭДНИЙ ОНЦЛОГ, СУРАХ ХЭВ МАЯГТ НИЙЦСЭН ХӨГЖЛИЙН ЦОГЦ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ, ТОХИРОХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮНЭЭР ХАНГАХ, СУРЛАГЫН ХОЦРОГДЛЫГ НӨХӨХ, АРИЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЖ, СУРЛАГЫН АМЖИЛТАД АХИЦ ГАРГАХ:

Хөгжлийн ялгаатай хүүхдийн хэрэгцээнд зориулсан тохируулгат орчин бүрдүүлсэн. Үүнд: Ариун цэврийн өрөөнд зориулалтын бариул, харааны бэршээлтэй хүүхдүүдэд зориулсан шатны тэмдэглэгээ, брайл бүхий сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэсэн.








## БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛЬД СУУРИЛСАН БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙГ БИЙ БОЛГОЖ, АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН БАГШ АЖЛЫН БАЙРАНДАА МЭРГЭЖЛЭЭ ДЭЭШЛҮҮЛЭХ, ҮР ЧАДВАРТ ГАРСАН АХИЦ, ҮР ДҮНГ ТООЦОХ:

Суралцахуйд суурилсан 7 чиглэлээр мэргэжлийн хөгжлийн бүлэг ажиллаж дараах үр дүнд хүрсэн. Үүнд: Үеийн багаар хамтран ажиллаж 12 багийн 62 багш уулзалтын цагийн хуваарьтай болсноор 25 цагийн уулзалт зохион байгуулав. Суралцагчдад 12 удаа бүлгийн уулзалт зохион байгуулж давхардсан тоогоор 327 сурагч хамрагдсан, 20 бүлгийн 820 сурагчдад суралцахуйн зорилтын төлөвлөлт хийсэн. Сурлагын хоцрогдлыг бууруулах зорилгоор даалгаварт суурилсан үнэлгээ зохион байгуулж үнэлгээний 8 түвшингээр хазайлтыг гарган эцэг эх, асран хамгаалагчдад 2 удаа танилцуулсан. Судалгаат хичээл, үйл ажиллагааг 2-3 дугаар улиралд зохион байгуулж 6-р ангийн 75 сурагч монгол хэл, гадаад хэл судлагдахуун, түүх нийгмийн 7, 8-р ангийн 154 сурагч хамрагдлаа. Бага ангийн 2 судлагдахууны хичээл аймгийн МХБ-ийн 2, 5 дугаар ангийн 52 багш, 76 сурагчийг хамруулан арга зүй туршлагаа түгээн дэлгэрүүлсэн.








Сургуулийн судалгаа хөгжлийн “Шинэ Монгол” ТББ-аас хэрэгжүүлж буй сургуулийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх төсөлд хамрагдаж 12 үеийн багаар 4 чиглэлээр 1623 сурагч, 91 багш ажилтнууд үйл ажиллагаагаа төлөвлөж үр дүнгээ тооцсон. Менежментийн гарааны оношилгоогоор “сайн суурь тавигдсан проактив шинжтэй” гэж үнэлэгдсэн бөгөөд засан сайжруулах үйл ажиллагааг хичээлийн жилийн турш тасралтгүй зохион байгуулав.








Сурагчдын өөрийн удирдлагын 7 байгууллагад 228 суралцагч 7 багшийн чиглүүлэг дор үйл ажиллагаа явуулав. Энэ хичээлийн жилд сурагчдын зөвлөлийн гишүүд, ангийн дарга нарын чуулганыг 4 дүгээр сард Баяндун суманд бүсийн 5 сургуулийн хэмжээнд зохион байгуулж туршлага солилцон хэлэлцүүлэг хийв. Ирэх хичээлийн жилд мөрдөж хэрэгжүүлэх зөвлөмж гаргав.










## “ТЭРГҮҮЛЭХ БОЛОН ЗӨВЛӨХ БАГШИЙН МАНЛАЙЛАЛ”-ЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, АХМАД БАГШИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, БАГШ, АЖИЛТНЫ СОЛИЛЦООНЫ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ, ШИЛДЭГ ТУРШЛАГЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ:

Зөвлөх багш Ө.Одмандах нь “Бийрийн эгшиг” дугуйланг тогтмол хичээллүүлж “Бичиг соёл Дорнод” уран бүтээлийн үзэсгэлэнд дугуйлангийн төгсөгчид болон сурагчдын 30 гаруй бүтээлийг дэлгэв. Мөн “Бичиг соёл” төвийн салбарыг Дорнод аймагтаа хөдөө орон нутгаас анхлан нээсэн бөгөөд тус төв нь аймгийн иргэд, төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадварыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулна. Салбарын нээлтийн хүрээнд МХУЗ-ын багш, сурагчдад бийр болон хулсан үзгийн 2 өдрийн сургалтыг амжилттай зохион байгуулав. Зөвлөх багш Ө.Одмандах нь Монгол бичгийн улсын 18 дугаар олимпиадад хүрэл медаль хүртсэн амжилттай ажиллаж байна.







## БАГШ, АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДАД СТРЕССЭЭС СЭРГИЙЛЭХ, СЭТГЭЛ ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙРАНД ЭЕРЭГ УУР АМЬСГАЛ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭГ ҮЕ ШАТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ:

Багш, ажилтан, албан хаагчдын сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Сэтгэл зүйч зөвлөж байна” мэдээллийн самбарыг ажиллуулсан бөгөөд мэдээлэл, постерыг тогтмол шинэчилдэг. Мөн багш ажилчдын “Ажлаас халшрах хам шинж”-ийг илрүүлэх судалгааг авч дүгнэлт хийв. Сэтгэл хөдлөл мэдрэмжээ зөвөөр илэрхийлэх, хамт олны эерэг уур амьсгалыг нэмэгдүүлэх зорилготой “Сэтгэл зүйн тренинг” зохион байгуулж 4 заах аргын нэгдлийн 80 багш, ажилтныг хамруулсан.





## ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРНЫ ОРЧИНД ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, АЛИВАА ГАДУУРХАЛ, ДАРАМТ, ҮЕ ТЭНГИЙНХНИЙ ДЭЭРЭЛХЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ, ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛЖ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, СУРАХ, ХӨГЖИХ, ТӨЛӨВШИХ, ҮЙЛ ЯВЦЫГ ДЭМЖИХ ТУСГАЙЛСАН АРГА ХЭМЖЭЭГ БАГШ, АЖИЛТАН, ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО, ТҮНШЛЭЛД ТУЛГУУРЛАН ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮР ДҮНГ ТООЦОХ:

Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг багш ажилчдад танилцуулан гарын үсгээр баталгаажуулж, мөрдөн ажиллаж байна. Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй аяны хүрээнд дунд, ахлах ангийн сурагчдын дунд эшлэл, урилга уралдаан, бага ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан зарлаж нийт 150 гаруй сурагч оролцож 4000 гаруй хүнд түгээсэн. Мөн 1620 сурагчийг “Үе тэнгийн дээрэлхэлт” сургалтад хамруулж зөв ойлголт хандлагыг нэмэгдүүлсэн.










3-5-р ангийн 9 бүлгийн 268 сурагчдад “Ялгаатай байдлаа ойлгоё хүндэлье” сургалт, 6-9-р ангийн 6 бүлгийн 188 сурагчдад “Мэдрэмжээ хуваалцая” сэтгэл зүйн сургалт, 6-9-р ангийн 11 бүлгийн 428 сурагчдад бүлгийн зөвлөгөө, сэтгэл зүйн тренингийг зохион байгуулан ажилласан. Мөн өсвөр насны хүүхдүүдийн “Эхлэл” клубыг байгуулан үе тэнгийнхэндээ эерэг нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж байна.










Энэ хичээлийн жилд эцэг эх асран хамгаалагчид чиглэсэн 3 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж 1395 эцэг эхчүүдэд хүрч ажилласан. “Бага, дунд, ахлах ангийн хүүхдийн сэтгэл зүйн онцлог” сэдвээр мэдээлэл сургалтад 9 үеийн 36 бүлгийн 980 эцэг эх, “Одооны хүүхдүүд”, “Хүүхдийнхээ сэтгэл зүйг хэрхэн дэмжих вэ” сургалтад 254 эцэг эхчүүдийг хамруулж хүмүүжлийн эерэг арга зүйг эзэмшүүлэхэд нөлөөлөл үзүүлэв.






## БАЙГУУЛЛАГЫН ОРЧНЫ ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ, ДОТООД ХЯНАЛТЫГ ТОГТМОЛЖУУЛАН, ТУСГАЙЛСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ҮР ДҮНГ ТООЦОХ:

Сургуулийн хүүхэд хамгааллын баг сургуулийн гадна орчинд 2, дотор орчинд 3 удаа үнэлгээ зохион байгуулсан. Үнэлгээгээр гадна орчны эрсдэл 32.3, дотор орчны эрсдэл 11.2, орчны аюулгүй байдал 15.3 хувийн эрсдэлтэй үнэлэгдсэн бөгөөд гарсан эрсдлийг бууруулах хариу арга хэмжээг дотоод нөөц боломжоо ашиглан зохион байгуулсан.

Сургуулийн дотоод хяналт нь жилийн төлөвлөгөө гарган, улирал бүр дүгнэлтээ сургуулийн удирдлагад танилцуулж, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. Энэ хичээлийн жилд бага ангиудын цонхонд хязгаарлагч хийж хүүхдийн аюулгүй байдлыг хангасан, замын хурд сааруулагчийг хийх саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлэв.





## ШИНЭЛЭГ, ОНЦЛОГ, БУСДАД ТУРШЛАГА БОЛОХУЙЦ ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ:

Сургуулийн судалгаа хөгжлийн “Шинэ Монгол” ТББ-аас хэрэгжүүлсэн сургуулийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх төсөлд хамрагдсанаар:

- Сургуулийн соёл төлөвшлийн менежмент
- Багш нарыг багт нэгтгэх зохион байгуулалт
- Зүрх сэтгэлийн боловсролын хөтөлбөр
- Ажлын байран дээрх багшийн хөгжил
- Төгсөгчдийн эргэх холбоо зэрэг менежментийн брэнд ажлуудыг өөрийн сургуулийн онцлогт тохируулан нутагшуулах үйл ажиллагааг зохион байгуулав. Ингэснээр сургуульд хэвшүүлэх соёлын 5 дадал, “Яг цагтаа - Бүгд цугтаа” цагийн менежментийн дадал, үеийн багаар ажиллах зохион байгуулалт зэрэг нь хамт олны төлөвшил, байгууллагын соёлд эерэг өөрчлөлтийг үзүүлж байна.

# СУРГУУЛИЙН СОЁЛ ТӨЛӨВШЛИЙН МЕНЕЖМЕНТ

**Баруун гарын дүрэм**

Сургуулийн орчинд- урлаг танхим, спортын заал, кабинетаар хичээллэхэд баруун гарын дүрмэээ баримтлан явж сурсан. Сургуулийн таних тэмдэг, тэмдэглэгээний дагуу 89.2% нь хэвшсэн.



**Цаг ашиглалт**



Анги удирдсан багш нар өдөр өдрөө хариуцаад ангийн цаг ашиглалт, мөн сургуулийн таван дүрмийн хэрэгжилтэн дээр хамтарч ажилласан. Үүний үр дүнд хичээлийн хоцролт багасаж, хүүхдүүд хоцрохгүй байхыг хичээдэг болсон. 34.3% хичээлээс хоцорч байсан бол буурсан. 4.6 % хоцордог энэ нь өмнөх улирлаас 1.2 %иар буурсан

**“07:55” Цаг бол алт аян ахлах ангид хэрэгжүүлсэн**

**Дүрэмт хувцсаа бүрэн өмсөх**

Сургуулийн эмч, үеийн багийн багш нар өдөр бүр хяналт хийн, тооцоо тэмдэглэгээтэй ажиллалаа. Үүний үр дүнд сурагчид сургуулийн дүрэм, сурагчийн ёс зүйг ойлгох, сахих, хэвшүүлэх соёлд суралцаж 90,2% тай байна.



Мэндлэх хүндлэх дадлыг хэвшүүлэн сургуулийн удирдлага, жижүүр багш, сурагчдын төлөөлөл өдөр бүрийн угталтыг хэрэгжүүлсэн.
Сургуулийн дадал хэвшлийг 1620 сурагч, 89 багш, ажилтнууд хамтран хэрэгжүүлж байна. Суурь боловсролын сурагчдын 76,6% дүрэмт хувцсаа жигд өмсдөг, 25,6% нь цамц, зангиагаа бүрэн өмсдөг. Бага боловсролын сурагчдын 90,2% дүрэмт хувцсаа жигд өмсөж хэвшсэн. Угталтын мэнчилгээг нийт сурагчдын 50,2% нь тогтмол хийж хэвшсэн. Бага боловсролын сурагчдын 89,2% нь баруун гарын дүрмийг мөрдөж хэвшсэн.

**Мэндлэх, Хүндлэх**

Хичээлд ирэх бүрд сургуулийн удирдлагын баг болон ангиудын хуваарьт сурагчид харилцан мэндийн үг хэлэх зэрэг үйл ажиллагааг 3-4 дүгээр улирлын турш зохион байгуулсан.
Сурагчдын 50,2% нь тогтмол хийж хэвшсэн.





# БАГШ НАРЫГ БАГШ НЭГТГЭХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ХЭРЛЭН СУМЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН БАГТ НЭГТГЭСЭН ХУВААРИЛАЛТ

(2023-2024 оны хичээлийн жил

| № | Баг | Багшийн нэр | Албан тушаал | Хүйс | Нэмэлт тайлбар | Яагаад энэ багт хуваарилсан бэ? | Сургуулийн менежментийн багийн гишүүд |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1-р баг | Д.Бат-Эрдэнэ | Бага ангийн багш | эм | 1а ангийн багш | Анги удирдсан багш | М.Хараа |
| 2 | | Ж.Дарьханд | Бага ангийн багш | эм | 1а ангийн багш | | |
| 3 | | Г.Нарангэрэл | Бага ангийн багш | эм | 1а ангийн багш | | |
| 4 | | Б.Тумэнжаргал | Бага ангийн багш | эм | 1а ангийн багш | | |
| 5 | | М.Мөнхжаргал | Хөгжмийн багш | эм | | Хөгжмийн хичээл ордог | |
| 1 | 2-р баг | Г.Оюундарь | Бага ангийн багш | эм | 2а ангийн багш | Анги удирдсан багш | С.Энхзаяа |
| 2 | | Р.Март | Бага ангийн багш | эм | 2а ангийн багш | | |
| 3 | | Д.Олонбаяр | Бага ангийн багш | эм | 2а ангийн багш | | |
| 4 | | б.Болорчимэг | Бага ангийн багш | эм | 2а ангийн багш | | |
| 5 | | м.Мөнхбат | Биеийн тамирын багш | эр | | Бага ангийн биеийн тамирын хичээл ордог | |
| 1 | 3-р баг | У.Нандинцэцэг | Бага ангийн багш | эм | 3а ангийн багш | Анги удирдсан багш | М.Одончимэг |
| 2 | | Ч.Сарангэрэл | Бага ангийн багш | эм | 3а ангийн багш | | |
| 3 | | д.Отгонцэцэг | Бага ангийн багш | эм | 3а ангийн багш | | |
| 4 | | М.Отгончимэг | Бага ангийн багш | эм | 3а ангийн багш | | |
| 5 | | О.Батбилэгт | Биеийн тамирын багш | эр | | Бага насны сурагчдад тоглоомын аргаар хичээл зохион байгуулах чадвартай | |
| 1 | 4-р баг | Г.Алтантуяа | Бага ангийн багш | эм | 4а ангийн багш | Анги удирдсан багш | М.Одончимэг |
| 2 | | Б.Баяржаргал | Бага ангийн багш | эм | 4а ангийн багш | | |
| 3 | | С.Энхзаяа | Бага ангийн багш | эм | 4а ангийн багш | | |
| 4 | | Ж.Долгормаа | Бага ангийн багш | эм | 4а ангийн багш | | |
| 5 | | О.Ганзориг | Хөгжмийн багш | эр | | Бага ангид хөгжмийн хичээл орж буй | |
| 1 | 5-р баг | Д.Ариунзул | Бага ангийн багш | эм | 5а ангийн багш | Анги удирдсан багш | М.Хараа |
| 2 | | Ш.Мягмарсүрэн | Бага ангийн багш | эм | 5а ангийн багш | | |
| 3 | | Н.Дашпагам | Бага ангийн багш | эм | 5а ангийн багш | | |
| 4 | | С.Энхзаяа | Бага ангийн багш | эм | 5а ангийн багш | | |
| 5 | | Х.Хишигсүрэн | англи хэлний багш | эм | | Бага ангид англи хэлний хичээл зааж буй | |
| 1 | | Э.Оюун-Эрдэнэ | түүх нийгмийн багш | эм | 6а ангийн багш | Анги удирдсан багш | |
| 2 | | Б.Баттуул | Монгол хэл, уран зохиолын багш | эм | 6б ангийн багш | | |

Удирдлагын баг ярилцаж багш нарыг багт нэгтгэх хуваарилалт хийсэн



Уулзалтын цагийг хичээлийн хуваарьт оруулсан

64 багш 12 ангийн үеийн багаар ажиллаж байна. Энэ хугацаанд 1,2,5,6,7,8,9,10,11,12 дугаар ангийн үеийн багийн багш нар 7 хоног бүрийн уулзалтыг үндсэн 4 чиглэлээр тогтмол хийж хэвшсэн байна.





Багт нэгтгэх арга зүйг хэрэгжүүлснээр 12 баг нийт 82 ажил төлөвлөснөөс 80 буюу 97% гүйцэтгэлтэй, бусдад туршлага болохуйц 8 үйл ажиллагаанд нийт 1200 сурагч хамрагдсан байна.








***Багийн уулзалтад багш нарын 67,1% нь 100%-ийн ирцтэй оролцсон нь өмнөх улирлаас 1%иар ахисан.. Огт оролцоогүй 1 багш байна.***









# ЗҮРХ СЭТГЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР



## 2 дугаар анги –Шорголжны аялал

Дорнод аймгийн Хэрлэн сумын “Найнги ХХК” 2-р ангийн 48 сурагч буюу 29% үйл ажиллагаатай танилцсан. Энэхүү үйл ажиллагаагаар сүүгээр “цөцгий, сүүн зайрмаг, сүүн ааруул, тараг, нэрмэл хийх аргатай танилцсан. Мөн тахиа болон нугас, ботго, унага, тугал зэрэг таван хошуу малын төл болон тэжээвэр амьтдын тухай мэддэг болсон.



## 4 дүгээр анги- Шорголжны аялал

“Шорголжны аялал” нэртэй үйл ажиллагаар 2024.05.24-нд зохион байгуулж нийт 23 км явган аялал хийж орон нутгийн дурсгалт газраар аялсан.
Багийн 4 багш, нийгмийн ажилтан 170 сурагч хамрагдлаа.



## 6 дугаар анги -Хөдөөгийн баясгалан

“Хөдөөгийн баясгалан” амьдрах ухааны хөтөлбөр. Дорнод аймаг, Сэргэлэн суманд зохион байгуулагдсан.
93 сурагч, үеийн багийн багш - 6, нийгмийн ажилтан сэтгэл зүйч - 3, сургуулийн тогооч -1, эцэг эх - 4. ингээд нийт 107 хүн хамрагдсан.



## 7 дугаар анги –Миний нутгийн бахархал

“Үзэмчин ястны ёс заншил, өв уламжлал” танин мэдэхүйн аяллыг Дорнод аймгийн Баянтүмэн суманд 5 сарын 25-ы өдөр зохион байгууллаа.
Үеийн багийн 91 сурагч, 5 багш, 4 эцэг эх оролцсон.



## 8 дугаар анги – Таван тансаг

"Малчны хотонд" танин мэдэхүйн аялал Дорнод аймгийн Баянтүмэн суманд 5 сарын 26-ы өдөр зохион байгуулсан. Нийт 58 сурагч, 12- эцэг эх 2 багш үйл ажиллагаанд хамрагдан оролцсон



## 9 дүгээр анги -Торгон хилийн зүг

Үеийн багийн хөвгүүдийг хамарсан арга хэмжээ зохиосон нь онцлог байлаа. "Эх оронч үзэл төлөвшүүлэх" үйл ажиллагаа Дорнод аймаг дахь цагдаа, цэргийн байгууллагатай хамтран явууллаа. Нийт 93 сурагч хамрагдлаа.



## 10 дугаар анги - Эх түүхийн жимээр

"Хэрлэн барс хотын туурь" үзэх аялал, орон нутгийн түүх дурсгалаар аялах үйл ажиллагаа А 6 сарын 9-нд зохион байгуулагдаж сурагчдын 80% хамрагдсан. Үзсэн зүйлсээр АХА тэмцээн зохион байгуулж нэгтгэн дүгнэсэн



## 11 дүгээр анги – Нутгийн бахархал

"Буриад ястны ёс заншил, ажил амьдралтай танилцах“ хөтөлбөр Дорнод аймгийн Баяндун суманд зохион байгуулагдаж 65 сурагч хамрагдлаа.

# ЗҮРХ СЭТГЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР

| 2024 ОНЫ 4 САРЫН 9 НөөС 6 САРЫН 9 | |
|---|---|
| ХӨТӨЛБӨР | 8 |
| СУРАГЧ | 1020 |
| БАГШ | 39 |
| БУСАД | 11 |

## БАГИЙН ГИШҮҮД-ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ






## СУРАГЧДЫН ЧАДВАР




## СУРАГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ




Үр дүнгийн үнэлгээ: 2024 оны 06 дугаар сарын 9 google form судалгааны нэгтгэн харуулав

# АЖЛЫН БАЙРАН ДЭЭРХ БАГШИЙН ХӨГЖИЛ

БАГТ НЭГТГЭХ МЕНЕЖМЕНТЭЭР АЖИЛЛАСНААР:

1




Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа бид сургуулийн менежементийн нэгдсэн зураглалтай холбож багшийн дүр төрөө тодорхойлсон.

2

БАГШИЙН ДҮР ТӨРХ




3

БАГТ НЭГТГЭХ АРГА ЗҮЙ – БАГШИЙН ХӨГЖИЛД НӨЛӨӨЛӨХ НЬ




*2024.06.09 ний нэгдсэн дүгнэлтийн санал асуулгаас*

4

Үр дүн:

Багшийг багт нэгтгэх хүрээнд суралцахуйд суурилсан мэргэжлийн хөгжлийн 7 бүлэг ажиллаж 12 багийн 62 багш 7 хоногийн уулзалтын цагтай болсноор 25 цагийн уулзалт зохион байгуулж багаар хамтран ажиллаж харилцан суралцлаа.

“Сурагчийн явцын үнэлгээ, ялгаатай суралцахуйн арга зүйг боловсруулах” төслийн туршилтын үндэсний 8 сургуулийн нэгээр сонгогдон бага, математик, физик, биологи, нийгмийн ухааны хичээлүүдээр туршилт үйл ажиллагааг зохион байгуулан, 5 багш, 2 удирдах ажилтан үндэсний сургагч багшийн эрх авсан. Ингэснээр үндэсний сургагч багш нар ирэх хичээлийн жилд шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх сургалт үйл ажиллагааг зохион байгуулахаар бэлтгэгдсэн болно.

2.1.4






# ДҮГНЭЛТ

1

Багш сурагчдын Үеийн багийн хамтын ажиллагаа ахисан.
Багийн уулзалтын оролцоо, хандлага 92% д хүрсэн.
Багийн оролцоо, үйл ажиллагааны үр дүнг нэтгэн дүгнэж сурагчдын оролцоо хандлага, сургалтын чанарт ахиц гарсан бусдад үр нөлөөтэй сайн туршлагатай баг хамт олны урамшуулан ажиллаж байна.

| № | Баг | Багшийн нэр | Албан тушаал | Хүйс | Долоо хоног 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | | | Зүрх сэтгэлийн боловсрол хөтөлбөрийн хүрээнд хийсэн үйл ажиллагаа: Сайн туршлагын нэр | Оролцогчдын тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1-р баг | Д.Бат-Эрдэнэ | Бага ангийн багш | эм | и | и | и | и | и | и | и | и | 100 | 97 | "Амжилтын баяр"-Бидний баяр үйл ажиллагааг 1 дүгээр ангийн 4 бүлгийн суралцагчдын дунд өртөөчилсөн хэлбэрээр зохион байгуулсан.Сурагчид бүлгийн дараалльн дагуу үнэлгээний дэвтрээ барин өртөө бүрт очиж даалгавраа хийж гүйцэтгэсэн.Мэдлэг чадварын тайлан 4 үе шаттайгаар явагдсан. 1-р өртөө "Зөв унших чадвар "2-р өртөө "Сайхан бичих чадвар" 3-р өртөө "Зөв бичих чадвар" 4-р өртөө "Тооцоолох чадвар" гэсэн өртөөгөөр хүүхэд бүр аялж, уншиж, бичиж, тооцоолон бодож өөрийн сурсан мэдсэн чадварын тайлангаа багш нар, болон эцэг эх,асран хамгаалагчдад харуулсан. | 4 бүлгийн 157 сурагчид 121- эцэг эх 9 багш нар үйл ажиллагаанд хамрагдан оролцсон. |
| 2 | | Ж.Дарьханд | Бага ангийн багш | эм | и | и | и | и | и | и | и | и | 100 | | | |
| 3 | | Г.Нарангэрэл | Бага ангийн багш | эм | и | и | и | и | и | и | и | и | 100 | | | |
| 4 | | Б.Тумэнжаргал | Бага ангийн багш | эм | и | и | и | и | и | и | и | и | 100 | | | |
| 5 | | М.Мөнхжаргал | Хөгжмийн багш | эм | и | и | и | и | и | ч | и | и | 88 | | | |
| 1 | 2-р баг | Г.Оюундарь | Бага ангийн багш | эм | и | и | и | и | и | и | и | и | 100 | 93 | Дорнод аймгийн Хэрлэн сумын "Найнпи ХХК" 2-р ангийн 48 сурагч буюу 29% үйл ажиллагаатай танилцсан. Энэхүү үйл ажиллагаагаар сүүгээр "цөцгий, сүүн зайрмаг, сүүн ааруул, тараг, нэрмэл хийх аргатай танилцсан. Мөн тахиа болон нугас, ботго, унага, тугал зэрэг таван хошуу малын төл болон тэжээвэр амьтдын тухай мэдлэг болсон. | 4 бүлгийн төлөөлөл 48 сурагчид 10 эцэг эх- Үеийн бүлгийн 4 багш нар,СНА, үйл ажиллагаанд хамрагдан оролцсон. |
| 2 | | Р.Март | Бага ангийн багш | эм | и | и | и | и | и | и | и | и | 100 | | | |
| 3 | | Д.Олонбаяр | Бага ангийн багш | эм | и | и | и | и | и | и | и | и | 100 | | | |
| 4 | | Б.Болорчимэг | Бага ангийн багш | эм | и | и | и | и | и | и | и | и | 100 | | | |
| 5 | | М.Мөнхбат | Биеийн тамирын багш | эр | и | и | и | ч | ч | ч | и | и | 63 | | | |
| 1 | 3-р баг | У.Нандинцэцэг | Бага ангийн багш | эм | и | и | Амралт | | | | | | | 81 | | |
| 2 | | Ч.Сарангэрэл | Бага ангийн багш | эм | и | и | и | и | и | и | и | | 100 | | | |
| 3 | | Д.Отгонцэцэг | Бага ангийн багш | эм | и | и | и | и | и | и | и | | 100 | | | |
| 4 | | М.Отгончимэг | Бага ангийн багш | эм | и | и | 4 анги | | | | | | | | | |

2

Сургуулийн 5 дадлыг хичээлийн жилийн 2 дугаар улирлаас тогтмолжуулж мэндлэх хүндлэх ёс 78.8, бага ангийн дүрэм хувцас 95.7, баруун гарын дүрэм 78,8%, сурагчдын хичээлийн хоцролт өмнөх улирлаас 1,12 %-иар буурсан зэрэг ололттой байна.





4

Сургуулийн онцлогтой Амьдрах чадварт суралцах хөтөлбөр боловсруулж төлөвлөн 8 үйл ажиллагааг амжилттай зохион байгуулан үеийн багийн багш 100% хамрагдаж, нийт сурагчдын 62,6% нь хамрагдсан. Үйл ажиллагааны явцын үр дүнг контент хэлбэрт оруулан олны хүртээл болгосон.






3

Ажлын байран дээр багшийн хөгжил, багийн үйл ажиллагааны сайн туршлага зэргийг өөрийн сургуулийн онцлогт тохируулан нутагшуулах үйл ажиллагааг зохион байгуулж нийтдээ сургуулийн менежментийн 6 дэд хөтөлбөртэй болсон. /ЭШХ, ХҮ, ЭЭНТ, ЗСБ, ЗБ, АБ/










5





# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
# БАЯРЛАЛАА

**ЗАХИРАЛ М.АЮУШХОРЛОО**